ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 12 өдөр Дугаар А/51 Улаанбаатар хот

Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн
онцгой байдлын үед ЦССҮТ-ийн
ажиллах журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалт, Шадар сайд, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/418 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ЦССҮТ-ийн ажиллах журам"-ыг 1 дүгээр, Үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт үнэлгээний тайлангийн маягтын загварыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн батлсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж, "ЦССҮТ-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-нд тодотгол хийн ажиллахыг Тохиолдлын удирдлагын тогтолцооны Штабын дарга /Ч.Батболд/-д даалгасугай.

3. Журамтай батлагдсантай холбогдуулан гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж, үйл ажиллагаагаа нягт уялдуулан ажиллахыг багийн ахлагч нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР

1118266548 ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠣᠯ 9128905

080345

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2020 оны 11 дүгээр сарын 12-ны
өдрийн А/57 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

1118266548 ☎9128905

ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД ЦССҮТ-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Шадар сайд, Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/418 дугаар тушаалыг тус тус үндэслэн Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын улмаас хүн амын эрүүл мэндэд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний хангамжийн бэлэн байдал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цусны албаны хэмжээнд хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, гүйцэтгэх чиг үүрэг, бүрэлдэхүүнийг тодорхойлох, харилцан ажиллагаа хэрэгжүүлэх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэ журамд зохицуулаагүй, эсхүл зөрчилдсөн заалт ЦССҮТ-ийн төлөвлөгөө, зааварт тусгагдсан нөхцөлд Шадар сайд, Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/418 дугаар тушаалыг баримтлана.

1.3. ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцоог энэ журамд заасны дагуу томилгоожуулан Эрүүл мэндийн улсын албаны гишүүн, ЦССҮТ-ийн Ерөнхий захирал удирдана.

1.4. ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь Эрүүл мэндийн Улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны шийдвэр, үйл ажиллагаатай уялдуулж гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, мэдээлэл солилцох, бэлэн байдлыг хангах, эрсдэлийн үнэлгээ, тохиолдлын удирдлагын тогтолцоонд суурилсан хариу арга хэмжээг зохион байгуулах, эрсдэлийн харилцаа холбоог зохицуулах, нөөц бүрдүүлэх, сургалт, дадлага зохион байгуулах зэрэг арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.

1.5. Өдөр тутмын бэлэн байдлын үед ЦССҮТ-ийн гамшгийн өмнөх үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны штабын дарга хариуцна.

1.6. ЦССҮТ-ийн Ерөнхий захирал Эрүүл мэндийн улсын албанд байрлан ажиллах тохиолдолд ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцоог штабын дарга удирдана.

1.7. Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлага нь ЦССҮТ-ийн нэгжүүдийг тохиолдлын удирдлага, мэргэжил арга зүйгээр хангана.

1.8. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг Монгол улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/418 дугаар тушаалын дагуу зохион байгуулна.

ХОЁР. ТОХИОЛДЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ЧИГ ҮҮРЭГ

2.1. Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай, Донорын тухай хууль, Эрүүл мэндийн Улсын алба болон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

2.2. ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь энэ журмын 2.3, 2.4, 2.5-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3. Гамшгийн өмнөх үйл ажиллагааны чиглэлээр:

2.3.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан чиг үүрэг;

2.3.2. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүн, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

2.3.3. онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, бусад албадтай харилцан ажиллах төлөвлөгөө боловсруулж, батлуулах;

2.3.4. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-д заасны дагуу гамшгийн эрсдэлийг бууруулахад шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж, зарцуулах;

2.3.5. гамшгийн эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, үнэлгээнд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах;

2.3.6. гамшгаас хамгаалах чиглэлээр албаны тэмдэглэл, даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, ЦССҮТ-ийн хүрээнд баримтлах журам, заавар боловсруулж батлуулан хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хяналт үнэлгээ хийх;

2.3.7. гамшиг, осол, халдварын голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг тусгай

хувцас, хүн нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын дагуу ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2.3.8. ЦССҮТ-ийн хэмжээнд болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний сургалт, дадлага сургуулилтыг хийх;

2.3.9. салбар, байгууллага хоорондын шуурхай мэдээллийг харилцан солилцож байх;

2.3.10. ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь тайван цагийн болон идэвхжлийн үеийн гэсэн 2 горимтой ажиллах;

2.3.11. Тайван цагийн горимд Шуурхай удирдлагын баг ажиллах чиг үүргийг энэ журмаар зохицуулах.

2.4. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн ажиллагааны чиглэлээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үүргийг хэрэгжүүлж ажиллана:

2.4.1. Эрүүл мэндийн Улсын албыг тусгай мэргэжлийн заавар, зөвлөмж, мэдээ мэдээллээр цаг тухайд нь шуурхай хангах;

2.4.2. гамшиг болон аюулт үзэгдэл, осол, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ЦССҮТ-ийг ажлын тусгай горим болон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтын бүсэд хүч хэрэгслийг шуурхай томилон ажиллуулах;

2.4.3. гамшиг, осол, халдварын голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг тусгай хувцас, хүн нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын дагуу ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

2.4.4. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах Эрүүл мэндийн тусламжийн мэргэшсэн баг (EMT – Emergency medical team) -ийн сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах;

2.4.5. гамшиг, ослын үед ажиллах хээрийн болон явуулын цус цуглуулах төвийн журмыг батлуулан бусад цусны салбар төв, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.4.6. Гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээг удирдан зохицуулах чиг үүрэг бүхий нэгж ажиллуулах

2.5. Гамшгийн дараах сэргээн босгох, гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааны чиглэлээр:

2.5.1. Хохирлын хэмжээг тооцох

2.5.2. Эрүүл мэнд, халдваргүйтгэлийн багтай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллана.

Гурав: ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ УДИРДЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагын бүрэлдэхүүн /цаашид штаб гэх/ нь Эрүүл мэндийн улсын албаны гишүүн-ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга, штабын дарга /цаашид менежер гэх/, тандалтын баг, төлөвлөлт хяналтын баг, хариу арга хэмжээний баг, эрсдэлийн харилцаа холбооны баг, хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын баг, нөөцийн бэлэн байдал, хангалтын баг, санхүү хөрөнгө оруулалтын багийн ахлагч нараас бүрдэнэ.

3.2. ЦССҮТ-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг улирал, жилээр боловсруулан ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга батална.

3.3. Тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. Эрүүл мэндийн улсын албаны Тохиолдлын удирдлагын тогтолцоонд цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжтай холбоотой асуудлаар дэмжлэг үзүүлэх, удирдлагад нь ажиллах, ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцоог удирдах, гамшгийн төлөвлөгөөг баталгаажуулж, холбогдох шийдвэр гарган хяналт тавих;

3.3.2. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдалтай холбоотой үүрэг, даалгаврыг багийн ахлагч нарт өгөх;

3.3.3. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын эрсдэл, хохирол, хэрэгцээний үнэлгээг хийлгэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн үед цусны албаны тогтвортой ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах:

3.3.4. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн ЦССҮТ-ийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;

3.3.5. Тохиолдлын удирдлагын нэгжийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шийдвэр гаргах.

3.4. Тохиолдлын удирдлагын штабын дарга /менежер/ нь дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1. Менежер нь ЦССҮТ-ийн Захиргаа, маркетингийн албаны дарга байх

бөгөөд түүний эзгүйд Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга орлоно.

3.4.2. Тохиолдлын удирдлагын нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мэргэжлийн удирдлагаар хангах;

3.4.3. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдалтай холбоотой тулгамдсан асуудлыг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөх, санал, шийдвэрийн төслийг боловсруулах, холбогдох мэдээ, мэдээлэл, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, гамшгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээгээр Тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга, Эрүүл мэндийн улсын албыг хангах;

3.4.4. Шинээр дайчлагдсан ажилтнуудад хийх ажлын чиглэл, удирдамжийг танилцуулах;

3.4.5. Штабын бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;

3.4.6. Эрсдэлийн үеийн бүх төрлийн мэдээллийн агуулгыг хянаж, ТУТ-ны даргаар баталгаажуулах;

3.4.6. Штабын нэгдсэн хурлыг өдөр тутам зохион байгуулж, үйл ажиллагааны гүйцэтгэлтэй танилцаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх.

3.5. Тандалтын багийн эрх, үүрэг

3.5.1. Тандалтын багийн ахлагч нь Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга, орлогч нь Чанарын менежер, халдвар судлаач эмч байна.

3.5.2. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлыг үүсгэгч төрлөөс хамаарч эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу хийх, эрсдэлийн үнэлгээний тайланг менежерт хүргүүлэх;

3.5.3. Үйл явдлын тархалт, өрнөл, эрсдэлийг тогтоох, ЦССҮТ-ийн тусламж, үйлчилгээ, нөөцийн мэдээ, мэдээлэл, олон нийтийн хандлага, хэвлэл мэдээлэл, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг нөхцөл байдлын тандалт хийх, дүн шинжилгээ хийж, хэтийн төлөвийг тодорхойлж /гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед тусламж, үйлчилгээг зогсоох, тасалдсан тохиолдол сэргээх гэх мэт/, санал боловсруулж, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээг менежерт танилцуулах;

3.5.4. Халдварын голомтыг халдваргүйтгэх үйл ажиллагаа, хариу арга хэмжээг мэргэжил, арга зүйгээр хангах;

3.5.5. Тандалтын багийн бэлэн байдлыг хангаж, тандалт, судалгаа хийх лаборатори, бусад байгууллагатай хамтран ажиллах;

3.5.6. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд өөрийн хариуцсан чиглэлээр тусгах ажлын санал боловсруулан тайван цагийн горимд жилд 1 удаа, эсхүл шаардлагатай үед штабт, идэвхжлийн үед сар бүр төлөвлөлт, хяналтын багт хүргүүлэх, тайланг мөн хугацаанд хүргүүлэх;

3.5.7. Тандалт, тархвар зүй, халдвараас сэргийлэх чиглэлээр сургалт, дадлага зохион байгуулах;

3.5.8. ЦССҮТ-ийн болон дайчлагдсан бие бүрэлдэхүүнийг өртөлтийн өмнөх урьдчилан сэргийлэлтэд хамруулах, эрүүл мэндийг хянах ажлыг зохион байгуулах;

3.5.9. Тандалтын багийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, тандалтын болон нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээг менежерт тухай бүрд хүргүүлэх, төлөвлөлтийн багт гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайланг 7 хоног бүрийн баасан гарагийн 10 цагт хүргүүлэх.

3.6. Төлөвлөлт, хяналтын багийн эрх, үүрэг

3.6.1. Төлөвлөлт, хяналтын багийн ахлагч нь менежер бөгөөд Захиргаа, маркетингийн албаны дарга, орлогч нь Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга байна.

3.6.2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшгийн эрсдэлийн үнэлгээ, дадлага, сургуулилтын дүгнэлтэд тулгуурлан шуурхай боловсруулан Тохиолдлын удирдлагын штабаар хэлэлцүүлэн батлуулах, шаардлагатай тухай бүр тодотгол хийх;

3.6.3. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын идэвхжлийн үед гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд үндэслэн “ ..... үеийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө” –г 7 хоногоор боловсруулан баталгаажуулж, биелэлтийг хянах;

3.6.4. Төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх мэдээллийг авах;

3.6.5. Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг батлагдсан аргачлалд тулгуурлан тооцоолох, холбогдох багуудыг дээрх мэдээллээр хангах;

3.6.6. Хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянаж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.6.7. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тайланг сар бүр багуудаас авч, нэгтгэн, ТУТ-ны даргад танилцуулах;

3.6.7. “ ..... үеийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө” –ний

тайланг 7 хоног бүрийн баасан гарагийн 10 цагт бусад багаас авч нэгтгэн ТУТ-ны даргад хүргүүлэх.

3.7. Хариу арга хэмжээний багийн эрх, үүрэг

3.7.1. Хариу арга хэмжээний багийн ахлагч нь Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч, орлогч нь Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч байна.

3.7.2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд өөрийн хариуцсан чиглэлээр тусгах ажлын санал боловсруулан тайван цагийн горимд жилд 1 удаа, эсхүл шаардлагатай үед штабт, идэвхжлийн үед сар бүр төлөвлөлт, хяналтын багт хүргүүлэх, тайланг мөн хугацаанд хүргүүлэх;

3.7.3. Хариу арга хэмжээний багийн төлөвлөлтийг хийж, өдөр тутмын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих;

3.7.4. Голомтод хариу арга хэмжээ зохион байгуулах, голомтын халдваргүйжүүлэлтийг зохион байгуулах;

3.7.5. Мэргэжлийн байгууллагаас томилогдсон багтай харилцан ажиллах;

3.7.6. ЦССҮТ-ийн тусламж, үйлчилгээний өдөр тутмын бэлэн байдлыг хангуулах;

3.7.7. Хариу арга хэмжээний багийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээг менежерт тухай бүрд, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайланг 7 хоног бүрийн баасан гарагийн 10 цагт хүргүүлэх.

3.9. Эрсдэлийн харилцаа холбооны баг

3.9.1. Эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч нь Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч, орлогч нь Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан байна.

3.9.2. Багийн төлөвлөгөөг ЦССҮТ-ийн нийт ажилтан, багуудтай холбоо тогтоох болон бусад мэдээллийг хамруулах, холбогдох баг, цусны салбар төвөөс мэдээ, мэдээлэл авах, мэдээллээр хангах зарчмыг тусгах замаар боловсруулан хэрэгжүүлэх;

3.9.3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний саналыг төсвийн хамт боловсруулан тайван цагийн горимд жилд 1 удаа, эсхүл шаардлагатай үед штабт, идэвхжлийн үед сар бүр төлөвлөлт, хяналтын багт хүргүүлэх, тайланг мөн хугацаанд хүргүүлэх;

3.9.4. Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан тандалтын баг, холбогдох мэргэжлийн багаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг нэгтгэн нэгдсэн мэдээллийг тандалтын баг, менежерт өдөрт тутам танилцуулах;

3.9.5. Тохиолдолын удирдлагын штаб, бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийг хариуцах;

3.9.6. Тохиолдлын удирдлагын штабыг дотоод мэдээ, мэдээлэл, харилцаа холбоогоор хангах;

3.9.7. ТУТ-ны даргаар хянагдаж баталгаажсан өдөр тутмын мэдээ, мэдээлэл /сэрэмжлүүлэг, зөвлөгөө, уриалга гэх мэт/, сайн туршлага, эрсдэлийг даван туулсан түүх, цусны донорын алдаршуулалт, урамшуулалт зэргийг олон нийт, эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх, түгээх;

3.9.8. Хүн амын дундах хандлага, ойлголтын судалгаанд тулгуурлан залруулга мэдээлэл бэлтгэн гаргах, олон нийтийн сүлжээнд дүн шинжилгээ хийж, цаашдын чиглэлийн талаарх мэдээллийг боловсруулан тандалтын багт хүргүүлэх;

3.9.9. ЦССҮТ-ийн цахим хуудас, фэйсбүүк хуудас, хяналтын самбараар дамжуулан цусны донор, хүн амыг мэдээллээр тогтмол хангах;

3.9.10. Хэвлэлийн бага хурал зохион байгуулах бэлтгэлийг хангах, оролцогчдыг зохион байгуулах;

3.9.11. Олон улсын байгууллагад хүргүүлэх мэдээ, мэдээллийн төслийг бэлтгэх;

3.9.12. Эрсдлийн харилцаа холбооны багийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээг менежерт тухай бүрт, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайланг 7 хоног бүрийн баасан гарагийн 10 цагт хүргүүлэх.

3.10. Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын баг

3.10.1. Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын багийн ахлагч нь хүний нөөцийн менежер, хуулийн зөвлөх, орлогч нь сургалт, төслийн ажилтан байна.

3.10.2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тайланг сар бүр авч, нэгтгэн менежерт танилцуулах;

3.10.3. Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнд болон хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хүний нөөцийн судалгааг гарган дайчлан ажиллуулах, хуваарилах;

3.10.4. Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг мөрдөн ажиллах заавар, журмаар хангах, түргэвчилсэн сургалтад хамруулах;

3.10.5. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг холбогдох байгууллагатай хамтран журамд заасны дагуу зохион байгуулах;

3.10.6. Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын багийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээг менежерт тухай бүрт, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайланг 7 хоног бүрийн баасан гарагийн 10 цагт хүргүүлэх.

3.11. Нөөцийн бэлэн байдал, хангалтын баг

3.11.1. Нөөцийн бэлэн байдал, хангалтын багийн ахлагч нь Нягтлан бодогч, орлогч нь Нярав байна.

3.11.2. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, урвалж, оношлуурын хэрэгцээ, нөөцийн судалгааг хийх, шаардлагатай төсвийг тооцох, нөөцийн мэдээллийг цахимжуулах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, тайлан, мэдээг гарган тандалт, төлөвлөлтийн багт хүргүүлэх;

3.11.3. Нөөцийг хадгалах, хамгаалахад шаардлагатай агуулах, байр, байгууламжийн бэлэн байдлыг хангах;

3.11.4. Баг, алба, тасгуудад нөөцийг түгээх, аюулгүй байдлыг хангах;

3.11.5. Шаардлагатай хувцас, багаж хэрэгслийн нөөцийн тооцоо, судалгааг хийх, хуваарилах, ашиглалтад хяналт тавих;

3.11.6. Нөхцөл байдлын өөрчлөлт орсон үед байр, хүнсний болон бусад материалаар найдвартай хангах нөхцөлийг судлан хангалтыг хийх;

3.11.7. Нөөцийн бэлэн байдал, хангалтын багийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээг менежерт тухай бүрт, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайланг 7 хоног бүрийн баасан гарагийн 10 цагт хүргүүлэх.

3.12. Санхүү, хөрөнгө оруулалтын баг

3.12.1. Санхүү, хөрөнгө оруулалтын багийн ахлагч нь Санхүү, бүртгэлийн албаны дарга, орлогч нь Нягтлан бодогч байна.

3.12.2. Шаардагдах нөөцийн тооцоог хийж, бэлэн байдлыг хангах, нөөцийн мэдээллийг цахимжуулах, хяналт тавих;

3.12.3. Ажилласан цагийн бүртгэлд үндэслэн цалин, нэмэгдэл хөлс, нөхөх төлбөр, урамшууллыг бодож олгох;

3.12.4. Нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлж, гэрээ хэлцэл хийх, санхүүжүүлэх;

3.12.5. Шаардлагатай худалдан авалтыг хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулах;

3.12.6. Өдөр тутмын санхүүгийн тайланг ТУТ-ны даргад танилцуулах, архив үүсгэн баримтжуулах;

3.12.7. Санхүү, хөрөнгө оруулалтын багийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээг менежерт тухай бүрт, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайланг 7 хоног бүрийн баасан гарагийн 10 цагт хүргүүлэх.

3.13. Штабын нарийн бичгийн дарга

3.13.1. Штабын нарийн бичгийн дарга нь Архив-бичиг хэргийн эрхлэгч, орлогч нь эдийн засагч-статистикч байна.

3.13.2. Штабын нарийн бичгийн дарга нь штабын гишүүдээс санал авч, штабын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, холбогдох баримт бичгийн төсөл боловсруулах, хадгалах, хамгаалах, архив үүсгэх;

3.13.3. ЦССҮТ-ийн ТУТ-ны жил, сарын төлөвлөгөөнд тусгах асуудлыг багуудаас авч нэгтгэн төлөвлөлтийн багт хүргүүлэх, батлагдсан төлөвлөгөөг багуудад хүргүүлэх;

3.13.4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар судалгаа, тооцоо гаргах, үндсэн үзүүлэлт, холбогдох хавсралтыг боловсруулах;

3.13.5. Штабын болон ТУТ-ны, түүнчлэн хамтран ажиллагч байгууллага, аж ахуйн нэгжтэй хийх хурлыг зарлан хуралдуулах бэлтгэлийг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх, баримт бичгийг хадгалах, хамгаалах, архив үүсгэх;

3.13.6. Багуудаас ирүүлсэн тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, гамшгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн тайланг нэгтгэх, архивлан баримтжуулах.

Дөрөв. ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН, ОРЛОХ АЛБАН ТУШААЛТАН

4.1. Энэ тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан ажил үүргийн хуваарийн дагуу штабын бүрэлдэхүүн, түүнийг орлох албан тушаалтан ажиллана. Шаардлагатай тохиолдолд ЦССҮТ-ийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны даргын зөвшөөрлөөр бусад ажилтныг нэмэгдлээр ажиллуулж болно.

4.2. Тохиолдлын удирдлагын штабын бүрэлдэхүүнийг хүснэгт-1-д заасны дагуу орлон ажиллана.

Хүснэгт 1

Шифр	Гамшгаас хамгаалах албан үүрэг	Албан тушаал	Орлох албан тушаалтан
101	Эрүүл мэндийн улсын албаны гишүүн, ЦССҮТ-ийн ТУТ-ны дарга	ЦССҮТ-ийн Ерөнхий захирал	ЗМА-ны дарга
102	Штабын дарга, менежер	ЗМА-ны дарга	ЦЧАБА-ны дарга
103	Тандалтын багийн ахлагч	ЦЧАБА-ны дарга	Чанарын менежер, халдвар судлаач эмч
104	Төлөвлөлт, хяналтын багийн ахлагч	ЗМА-ны дарга	ЭШМТА-ны дарга
105	Хариу арга хэмжээний багийн ахлагч	ДЗБТ-ийн эрхлэгч	НЛТ-ийн эрхлэгч
106	Эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч	ҮТ-ийн эрхлэгч	Мэдээллийн технологийн инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан
107	Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын багийн ахлагч	Хүний нөөцийн менежер, хуулийн зөвлөх	Сургалт, төслийн ажилтан
108	Нөөцийн бэлэн байдал, хангалтын багийн ахлагч	Нягтлан бодогч	Нярав
109	Санхүү, хөрөнгө оруулалтын багийн ахлагч	СБА-ны дарга	Нягтлан бодогч
110	Штабын нарийн бичгийн дарга	Архив-бичиг хэргийн эрхлэгч	Эдийн засагч, статистикч

4.3. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын төрөл, эрсдэлийн түвшингээс хамаарч Тохиолдлын удирдлагын тогтолцоо, штаб хэсэгчлэн болон бүхэлдээ идвэхжиж болно.

4.4. Тохиолдлын удирдлагын тогтолцоо, штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн томилгоо хийж төлөвлөгөөнд тусгана.

4.5. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын онцлог, төрлөөс шалтгаалан багийн ахлагчийг орлох ажилтан болон менежерийг өөрчлөн томилж болно.

4.4. Шаардлагатай тохиолдолд ЦССҮТ-ийн орон тооны бус баг, хороо, зөвлөлийн

төлөөллийг нэмэлтээр татан оролцуулж болно.

Тав: ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 ЦССҮТ нь болзошгүй гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэнэ:

5.1.1 эрүүл мэндийн байгууллагын болон салбар дундын мэдээ, мэдээлэл солилцох;

5.1.2 эрсдэлийн үнэлгээ хийх;

5.1.3 эрсдэлийн үнэлгээнд үндэслэн төлөвлөлт хийх;

5.1.4 гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах сургалт зохион байгуулах;

5.1.5 бүрэлдэхүүний сургалт, ширээний дасгал сургалт, дадлага сургуулилтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

5.1.6 болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын мэдээллийн сан бүрдүүлэх;

5.1.7 эрсдэлийн үеийн харилцаа холбоо, хяналт үнэлгээ, тайлагналт зэрэг үйл ажиллагаанууд багтана.

5.2. Гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед тохиолдлын удирдлагын тогтолцоо нь дараах хариу арга хэмжээ, нөхөн сэргээх арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллана:

5.2.1. Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан эрсдэлийн үнэлгээ “өндөр”, “маш өндөр” түвшинд үнэлэгдсэн үед Тохиолдолын удирдлагын тогтолцоо идэвхжиж, журмын дагуу ажиллаж эхэлнэ.

5.2.2. үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллагаас үйл явдлын мэдээлэл, эрсдэлийн үнэлгээний тайланг авна.

5.2.3. тохиолдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005) болон энэхүү журмыг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын эрт, сэрэмжлүүлэг хариу арга хэмжээг зохицуулсан холбогдох бусад заавар, журмын хамт мөрдлөг болгоно.

5.3. Тохиолдлын удирдлагын тогтолцооны үйл ажиллагаа дараах үндсэн зарчимд суурилна:

5.3.1. шаталсан удирдлагын тогтолцоотой байх (бие бүрэлдэхүүний тайван цагийн албан тушаалын зэрэглэл, шатлал Тохиолдлын удирдлагын тогтолцоо идвэхжсэн үед үйлчлэхгүй);

5.3.2. бүх төрлийн эрсдэлийн хариу арга хэмжээнд тохирсон нэгдсэн бүтэц, загвартай байх;

5.3.3. нөхцөл байдлын өөрчлөлтөд мэдрэг, уян хатан байх.

5.4. Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь шаардлагатай үед 7/24 цагаар уртасгасан цагаар ажиллана.

5.5. Онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний нэгдмэл байдлыг хангах үүднээс үүссэн нөхцөл байдал, эрсдэлийн төрлөөс үл хамааран Дарга, эрсдэлийн харилцаа холбооны баг, хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын баг, санхүү, хөрөнгө оруулалтын баг, нөөцийн бэлэн байдал, хангалтын багийн гишүүд **байнгын** бүрэлдэхүүнтэй байна. Харин Менежер, бусад багийн бүрэлдэхүүнийг эрсдэлийн төрөл бүрт **ялгаатай** томилж болно.

5.6. Тохиолдлын удирдлагын нэгжийн бие бүрэлдэхүүн нь 2 цагийн дотор цугларна.

5.7. Тохиолдлын удирдлагын нэгжийн бие бүрэлдэхүүнд ажиллах ажилтнуудтай холбоо тогтоох боломжгүй (эзгүй, эрсдэлд өртсөн г.м) тохиолдолд орлон ажиллах ажилтныг дайчлан ажиллуулна.

5.8. Дээрх ажилтнуудтай холбоо тогтоох боломжгүй тохиолдолд Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежерийн шийдвэрээр тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, олон жил ажилласан мэргэжилтнийг сонгон ажиллуулна.

Хүснэгт №1

ЦССҮТ-ИЙН ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Нэгжийн дарга – (Зохицуулагч)
ЦССҮТ-ийн дарга Н.Эрдэнэбаяр

Штабын дарга - (Менежер) ЗМА-ны дарга Ч.Батболд

Тандалтын баг

Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
ЦЧАБА-ны дарга Т.Алимаа	Чанарын менежер, халдвар судлаач эмч Э.Тунгалагтуяа
Э.Тунгалагтуяа	Г.Цэндбаяр
Х.Мядагмаа	Э.Золбоо
Н.Баяртогтох	С.Ганчимэг
А.Номин-Өлзий	П.Цэндхүү
Б.Өнөрцэцэг	Б.Золгэрэл
С.Нандинцацрал	Д.Дулмаа

Төлөвлөлт, хяналтын баг

Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
ЗМА-ны дарга Ч.Батболд	ЭШМТА-ны дарга Л.Өнөрбаяр
Г.Мөнхсөёл	Ц.Энхмэнд
А.Түвшин	Г.Мөнхзаяа
Б.Соёлоо	Б.Оргил

Хариу арга хэмжээний баг

Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
ДЗБТ-ийн эрхлэгч Ч.Тунгалаг	НЛТ-ийн эрхлэгч М.Цэрэндэжид
М.Цэрэндэжид	Б.Соёлоо
Б.Өнөрцэцэг	Э.Дашгарав
Э.Тунгалагтуяа	А.Заяабилэг
Д.Дулмаа	С.Нандинцацрал
Е.Улсболд	Б.Делгөөн
Б.Оргил	Б.Золгэрэл

Эрсдэлийн үеийн харилцаа холбоо

Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
ҮТ-ийн эрхлэгч Н.Халиун	ХАБ-ын ажилтан Г.Мөнхзаяа
С.Нандинцацрал	Г.Мөнхсөёл
Ч.Далайцэрэн	Г.Мөнхзаяа
Д.Дулмаа	Г.Мөнхсөёл
Б.Делгөөн	Г.Цэндбаяр
Э.Золбоо	Д.Энхсүрэн
Түгээх хэсгийн сувилагч	

Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын баг

Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
ХНМХЗ Я.Тогтохнэм	Сургалт, төслийн ажилтан
Н.Тэрбишт огтох	А.Ананд
Б.Буянтогтох	Б.Есүүн
Б.Долгормаа	Б.Дуламсүрэн

Нөөцийн бэлэн байдал, хангалтын баг

Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
Нягтлан бодогч П.Оюунтунгалаг	Нярав Б.Алтанзул
Ц.Энхмэнд	Б.Додьгалсан
Г.Эрхэмбаяр	Хаянхярваа
Батбаяр	Батхүү
Ч.Далайцэрэн	Б.Алтанзул
С.Ганчимэг	Н.Тэрбишт огтох
Л.Өлзийбаяр	А.Номин-Өлзий
Э.Дашгарав	Д.Сарантуяа

Санхүү, хөрөнгө оруулалтын баг

Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
СБА-ны дарга Б.Өнөрзул	Нягтлан бодогч П.Оюунтунгалаг
Б.Алтанзул	Хаянхярваа

Зургаа: АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗААВАР

6.1. ЦССҮТ-ийн хэмжээнд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед хариу арга хэмжээний дараахь зааврын дагуу ажиллана.

24 цагийн дотор авах арга хэмжээ	24-72 цагийн дотор авах арга хэмжээ	3-10 хоногийн дотор авах арга хэмжээ	10-30 хоногийн дотор авах арга хэмжээ	30-60 хоногийн дотор авах арга хэмжээ
1. Эрүүл мэндийн байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагын хүрээнд				
- бүх ажилтны аюулгүй байдлыг хангана; - эрүүл мэндийн улсын алба, бусад байгууллагатай хамтран ажиллах шуурхай бэлэн байдлыг хангана; -гамшгаас хамгаалах болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг идэвхжүүлнэ. Үүнд: -тохиолдлын удирдлагын тогтолцооны менежерт мэдэгдэх; -мэдээллийг штабын гишүүдэд мэдэгдэнэ; -тохиолдлын удирдлагын багуудыг идэвхжүүлж, үндсэн чиг үүргийг нь	-Гамшиг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал болсон газарт ажиллах, дэмжлэг туслалцаа хүсэх, орон нутгийн удирдлагуудтай харилцаа холбоо тогтоох; - Гамшгийн нөөц санд зохих журмын дагуу хүсэлт гаргана -Дайчилгааны багийг хүлээн авч, холбогдох чиг үүргийг зохих журмын дагуу шилжүүлнэ. -Эрүүл мэндийн улсын алба, тусламжийн багийн уулзалтуудад Тохиолдлын удирдлагын тогтолцоог төлөөлж ЦССҮТ-ийн ТУТ-ын дарга оролцоно. -салбар хоорондын түргэвчилсэн үнэлгээний	-ЦССҮТ-ийн аюулгүй байдлын үнэлгээг шинэчилж, аюулгүй байдлыг хангах нэмэлт үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлно. -Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулахад өөрийн чиг үүргийн дагуу оролцоно. -Хэвлэлийн мэдээ, харилцаа мэдээллийн бусад материал боловсруулж гаргана (хамгийн багадаа долоо хоног тутам шинэчилнэ). - хандивлагч нартай хамтран ажиллана -Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой	-Хүний нөөцийн төлөвлөгөөг үнэлнэ. -Нөхцөл байдлын тайлан гаргах давтамжийг тодорхойлно (ж.нь, долоо хоногт 2 удаа, долоо хоног тутам). - хэрэгжиж байгаа хүмүүнлэгийн үйл ажиллагаанд бусад байгууллагатай хамтарсан хяналт тавина.	-Дайчилгааны хоёр дахь баг ирүүлэх хүсэлт гаргана. -Хүний нөөцөөр хангах урт хугацааны төлөвлөгөөг эцэслэнэ. - хариу арга хэмжээний саналуудыг хандивлагч байгууллагуудтай хуваалцана. -Шилжилтийн үеийн болон сэргээн босголтын төлөвлөлт хийх боломжуудыг судална.

тодорхойлно. - тохиолдлын удирдлагын тогтолцооны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт хүн хүч дайчлах хүсэлтийг Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдолын удирдлагын тогтолцооны штабт гаргана. -Эрт үеийн хариу арга хэмжээний зорилтууд дээр зөвшилцөнө. - Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдолын удирдлагын тогтолцооны штабтай харилцаа холбоо тогтооно. - Эрт үеийн хариу арга хэмжээг эхлүүлж, удирдана.	багт ажиллана -Эрт үеийн хариу арга хэмжээний стратеги, зорилт,үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.	байдлын үеийн хариу арга хэмжээний хүрээг хянах арга хэрэгслийг идэвхжүүлнэ. -Гүйцэтгэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээг эхлүүлнэ. -Цаашдын хэрэгцээг тодорхойлно.		
2.Тандалт, төлөвлөлт, хяналтын хүрээнд				
-Эрсдэл, хэрэгцээний хяналт-шинжилгээг тогтмол хийж, удирдлагыг	-нөхцөл байдлын дүн шинжилгээ,түргэвчилсэн үнэлгээ хийнэ. -Эрт үеийн хариу арга хэмжээний стратеги,	-Гамшигтай холбоотой эрүүл мэндийн мэдээ, мэдээллийг тогтмол хянаж, дүн шинжилгээ	-Түргэвчилсэн үнэлгээний эрүүл мэндийн хэсгийг боловсруулж хэрэгжүүлнэ.	-Тайлан мэдээллийн тогтолцоог сайжруулна. -Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн

мэдээллээр тухай бүр хангаж ажиллана.	зорилт, үйл ажиллагааны төлөвлөлтийг хангана. -Нөхцөл байдлын анхны тайланг боловсруулан гаргана. -4Х-ийн матриц боловсруулах буюу шинэчилнэ. -Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал буюу дэгдэлтийн үеийн нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг зохих заавар журмын дагуу эхлүүлнэ.	хийж, түгээнэ. -Багуудтай хамтран стратегийн ба үйл ажиллагааны төлөвлөлтийг зохицуулна. -Эхний нөхцөл байдлын тайланг боловсруулан гаргана. -Гамшгийн үеийн хариу арга хэмжээний хүрээний гүйцэтгэлийн хяналт- шинжилгээг хийнэ. -хариу арга хэмжээний тайлагналтыг жигдрүүлнэ.	-Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүхий хариу арга хэмжээний хяналт-шинжилгээний хүрээ боловсруулна. -Хариу арга хэмжээний төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэнэ. -Нөхцөл байдлын тайлан,тархварзүйн мэдээллийн хуудас, ЦССҮТ-ийн мэдээллийг гаргана. -Нөөцийн зураглалыг гаргана. -Хэрэгцээний нарийвчилсан үнэлгээг эхлүүлнэ.	түвшинг тогтмол (ж.нь, долоо хоног тутам, сар тутам) тайлагнана. -Байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хэрэгцээний үнэлгээ, нөөцийн зураглал зэрэгт хяналт-шинжилгээ хийсний үндсэн дээр гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгоно. -Шилжилтийн үеийн болон сэргээн босголтын төлөвлөлтийг зохицуулна.
3.Эрүүл мэндийн салбар доторх зохицуулалт, хамтын ажиллагааны хүрээнд				
-Хамтран ажилладаг бусад эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн засаг, захиргааны байгууллага болон ЭМЯ-тай харилцаа холбоо тогтооно.	-Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагуудтай цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн чиглэлээр хамтран ажиллах, салбар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд цус цуглуулалтыг нэмэгдүүлэх талаарх хүсэлтээ ЭМУА -нд	-Хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаанд шаардлагатай асуудлаа оруулна. -4Х (Хэн, Хаана, Хэзээ юуг Хэрхэн хийх)-ийн матриц ашиглан үйлчилгээний хүртээмжтэй холбоотой орхигдсон асуудлыг	-Хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад оролцоно. -Штабын хурал, уулзалтуудыг тогтмол (ж.нь.өдөр тутам, долоо хоногт 2 удаа)зохион байгуулна. -хариу арга хэмжээний хэрэгцээ,	-Зохицуулалтын чиглэлээр орхигдсон асуудлуудыг шийдвэрлэнэ. -Бусад салбартай үйл ажиллагааг зохицуулах механизмыг бэхжүүлнэ. -Шилжилтийн үеийн болон сэргээн босголтын төлөвлөлтөд хамтран

	хүргүүлж, зохицуулалт хийж ажиллана. -Цусны албанд ажиллуулах эмнэлгийн мэргэжилтний дайчилгааны анхны зураглалыг гаргана.	тодорхойлох, шийдвэрлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. -Салбар доторх уулзалт, үйл ажиллагаанд оролцоно. - ЦССҮТ-ийн Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ашиглах мэдээллийн эхний хэсгийг боловсруулан гаргана.	эрсдэл, үйл ажиллагааг үнэлнэ.	ажиллана.
4. Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын хүрээнд • Урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээ • Эрсдэлийн харилцаа холбоо • Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх • Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх • Эрүүл мэндийн ажилтнуудын сургалт, чадавхи бэхжүүлэх				
-Эрсдэлийн харилцаа холбоо зохион байгуулахтай холбоотой хаягийн бүртгэл, утасны дугаар, телефон утас, интернетийн сүлжээ, тоног төхөөрөмж гэх мэт бэлэн материал, мэргэжил аргазүйн удирдамжаар тохиолдлын	-Эрсдэлийн харилцаа холбооны мессеж боловсруулж, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг эхлүүлнэ. -Эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын дүн шинжилгээ,түргэвчилсэн үнэлгээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой	-Эрсдэлийн харилцаа холбоо, олон нийтийн оролцоо, өвчний хяналтын арга хэмжээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүний нөөцийн сургалтын чиглэлээр нэн түрүүнд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиг үүргийн дагуу	-Хариу арга хэмжээний төлөвлөгөө, үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг хэрэгжих боломжтой, мэргэжил аргазүйн хувьд үнэн зөв байлгахад анхаарна. -Тусламж үйлчилгээний	-Сургалтын үйл ажиллагааг өргөжүүлнэ. -Шилжилтийн үеийн болон сэргээн босголтын төлөвлөлтөд оруулна.

удирдлагын тогтолцооны багуудад дэмжлэг үзүүлнэ.	хэсгийг боловсруулахад мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлнэ. -Хариу арга хэмжээний стратеги, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой хэсгийг боловсруулна. -Багуудын харилцаа холбоог хангана.	ажиллана. -Эрсдэлийн харилцаа холбооны мессежийг боловсронгуй болгож, олон нийтийн оролцооны стратеги боловсруулна. -Үйл ажиллагаанд орхигдсон асуудлыг шуурхай шийдвэрлэх чиглэлээр ажиллана. -Эмчилгээ, оношлогоо, удирдамж, шилдэг туршлагыг үйл ажиллагаанд ашиглахыг дэмжиж, хяналт тавина. -Цусны салбар төвүүдэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээллээр хангана.	хамралт, чанартай холбоотой орхигдсон асуудлыг шийдвэрлэхэд эрүүл мэндийн бусад байгууллагатай хамтран ажиллана. -Олон нийтийн оролцоог хангах, эрсдэлийн харилцаа холбооны мессежийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн тухай бүр шинэчилнэ. -Эрүүл мэндийн ажилтны сургалтын хэрэгцээг хангах үйл ажиллагааг эхлүүлнэ. -Мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлнэ.	
6.Нөөцийн бэлэн байдал, хангалтын хүрээнд • Хангамжийн сүлжээний удирдлага • Эм, эмнэлгийн хэрэгсэл тоног, төхөөрөмжийн ханган нийлүүлэлт				
-Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлнэ: - Харилцаа холбоо, мэдээллийн технологи, тээврийн хэрэгсэл, ажлын байр нь үйл ажиллагаа	- Эм, эмнэлгийн хэрэгсэл тоног, төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, хэрэгцээний хурдавчилсан үнэлгээ хийнэ. -Агуулах, нөөцийн үнэлгээ хийнэ.	-Талбарт үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлнэ. Үүнд: Байраар хангах, ажиллах хүчний удирдлага, харилцаа холбоо, штабыг байраар хангах; -Хангамжийн сүлжээг	-Хангамжийн сүлжээ, бараа материалын ханган нийлүүлэлт, талбарт дэмжлэг үзүүлэх хэрэгцээний нарийвчилсан үнэлгээ хийнэ. -Ханган	-Ханган нийлүүлэлт, хүн хүчний хэрэгцээг үнэлнэ. -Шилжилтийн үеийн болон сэргээн босголтын төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

явуулахад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ. -Эмнэлгийн хэрэгсэл, багцын түгээлтийг эхлүүлнэ.		бэхжүүлэх (урьдчилсан тооцоолол хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах. хадгалах, тээвэрлэх түгээх, түншүүдийн үйл ажиллагааг зохицуулах) үйл ажиллагааг эхлүүлнэ. -Бараа, материалын тээвэрлэлтийг зохион байгуулна. -Ханган нийлүүлэлтийн үнэлгээнд оролцоно. - Эм, эмнэлгийн хэрэгсэл болон бусад бараа материалын ханган нийлүүлэлтийн стандарт, удирдамжаар түншүүдийг хангана.	нийлүүлэлтийн уулзалтад оролцож, хамтран ажиллана. -Дэмжлэгийг өргөжүүлнэ. -Хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.	
6. Санхүү, хөрөнгө оруулалтын хүрээнд • Санхүү, Төсөв/буцалтгүй тусламжийн удирдлага • Худалдан авах ажиллагаа • Хүний нөөц ба дайчилгааны санхүүжилт				
-Тохиолдын удирдлагын тогтолцооны бэлэн байдлын төлөвлөгөөг	-Гамшгийн үеийн захиргааны, хүний нөөцийн, санхүүгийн,	-тохиолдлын удирдлагын тогтолцооны даргын баталсан нэн чухал	-Гамшгийн үеийн хүний нөөц, үйл ажиллагааны төлөвлөгөө,төсөв	-Дайчилгааны 2 дахь баг буюу урт хугацааны ажилтнуудыг

идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. -Гамшгийн үед хэрэглэх санхүүгийн нөөц, боломжийг тогтооно.	буцалтгүй тусламжийн удирдлагын, худалдан авах ажиллагааны үйлчилгээ үзүүлнэ. -Монгол Улсын хууль, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд болон Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын төв байгууллагаас гаргасан гамшгийн үед ажиллах журам, стандарт, үйл ажиллагааны удирдамжийг хэрэгжүүлнэ.	үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. - дайчлагдсан ажилтнуудыг тохоон томилж, тохиолдлын удирдлагын тогтолцооны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. -Дайчлагдсан ажилтнуудад зааварчилгаа өгнө. -Хандивлагчдын санхүүжилтийг хянаж, зориулалтын дагуу зарцуулах, цаг тухайд нь тайлагнахад анхаарна.	боловсруулна. -Ажилтны сэлгэлтийг зохион байгуулна. (дайчлах, хүлээлгэн өгөх, буцаах)	хүлээн авахад бэлтгэнэ. -Шилжилтийн үеийн болон сэргээн босголтын төлөвлөлтөд оролцоно.

Долоо: Бусад

7.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2020 оны 11 дүгээр сарын 12-ны
өдрийн 451 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

1118266548 ᠳᠤᠨᠳᠠᠭᠠᠳᠤ᠍ᠬᠠᠪᠴᠠᠭᠠᠯᠲᠠ᠍ᠨ᠂ᠬᠠᠪᠴᠠᠭᠠᠯ᠂ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ᠍

	Үзүүлэлт	Гүйцэтгэл
9	Зарцуулалт эх үүсвэр тус бүрээр	Байгууллагын төсөв - ЭМЯ ны төсөв – Улсын нөөц – ДЭМБ - Бусад -
10	Төлөвлөгөөнд тодотгол хийгдсэн эсэх	☐ Тийм ☐ Үгүй Тийм бол хийгдсэн огноо __ __ __ __
11	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн үйл явдлын тоо	
12	Үүнээс баталгаажуулсан нь	
13	Эрсдэлийн үнэлгээ хийсэн нь	
14	24 ц дотор мэдээлсэн үйл явдал	
15	24 ц дотор хариу арга хэмжээ авсан	
16	Бусад байгууллагуудад мэдээлсэн үйл явдлын тоо	
17	Бусад байгууллагаас мэдээлсэн үйл явдлын тоо	
18	Цус, цусан бүтээгдэхүүн цуглуулсан тоо	
19	Цус, цусан бүтээгдэхүүнд шинжилгээ хийсэн тоо	
20	Цус, цусан бүтээгдэхүүний нөөц O(+) ..... O(-) ..... A(+)..... A(-) ..... B(+) ..... B(-) ..... AB(+) ..... AB(-) ..... Сийвэнгийн бүтээгдэхүүн .... Улаан эсийн бүтээгдэхүүн	
21	Эрт сэрэмжлүүлэх тогтолцоогоор илрүүлсэн дэгдэлтийн тоо	
22	Лабораториор баталгаажуулсан дэгдэлтийн тоо	
23	Лабораториор баталгаажуулсан үйл явдлын тоо	

	Үзүүлэлт	Гүйцэтгэл
24	Лабораторийн тоо	
25	Үүнээс үндэсний лавлагаа лаборатори	
26	Лабораторийн гадаад чанарын хяналтад хамрагдсан эсэх	
27	Лабораторийн дотоод чанарын хяналтад хамрагдсан эсэх	
28	Бэлэн байдлын дадлага, сургуулилтын тоо. Үүнээс: -Хэсэгчилсэн -Иж бүрэн -Хамрагдсан хүний тоо	
29	Эрсдэлийн харилцаа холбооны багтай эсэх	☐ Тийм ☐ Үгүй
30	Веб хуудастай эсэх	☐ Тийм , хаяг: ☐ Үгүй
31	Фейсбүүк хуудастай эсэх	☐ Тийм , хаяг: ☐ Үгүй
32	Сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэдэг сувагтай эсэх	☐ Тийм ☐ Үгүй Тийм бол ямар: ФМ радио, үүрэн телефон, тв, сонин, веб гм